



Хот, суурин газрын орчны нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Дэлхийн хотжилтын чиг хандлага, хотуудын тэлэлт, хүн амын өсөлт, хотын орчны доройтол зэргээс үүдэн хотуудын ирээдүйн төлөв, хотын оршин суугчдын амгалан тайван амьдрах асуудалд анхаарлаа хандуулах шаардлага үүсгээр байна.

Энэхүү асуудал нь хотын оршин суугчид болон тэдний хүрээлэн буй орчин болох хотын орчин, амьдралын орон зайн хоорондын харилцаа юм. Уг хүн ба хүрээлэн буй орчны харилцааны мөн чанарыг судлах нь газар зүйн судалгааны чухал асуудал билээ.

Хот, суурин газрын амьдрах таатай байдлын талаарх ойлголт нь оршин суугчидын үнэлэмжээс хамаардаг байна. Уг үнэлэмж нь ихэвчлэн хүрээлэн буй орчны шинж чанар, хүний зан үйл хоорондын харилцан үйлчлэлийн хоорондын харьцаанаас хамаарна.

Хот, суурин газрын амьдрах орчны нөхцөл байдлыг хотын иргэдийн амьдралын чанарт нөлөөлж буй стресс үүсгэх хүчин зүйлсийг тодорхойлсноор гаргаж ирдэг байна.

Байгалийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлс:

Хөрсний гулсалт

Хөрсний гулсалт нь хот төлөвлөхөд зайлшгүй анхаарах ёстой чухал зүйл юм. Хөрсний гулсалт ихэвчлэн уур амьсгал, газар хөдлөлт, үер, усны эвдрэл, түймэр, уул уурхай зэргээс шалтгаалан үүсдэг байна. Харин хөрсний гулсалт нь хөдөө аж ахуй, барилга байгууламж барих, дэд бүтцийн бүтээн байгуулалтанд асар их сөрөг нөлөө үзүүлэхүйц хүчин зүйлд тооцогддог байна.

Газар хөдлөлт

Газар хөдлөлт нь олон сөрөг үр дагаврыг дагуулдаг. Тухайлбал, газрын гадаргуун эвдрэл, хөрсний гулсалт, галт уулын идэвхижил, барилга, байгууламжийн эвдрэл, сүйрэл гэх мэт. Гиймээс хот төлөвлөх, барилгын чанар, стандарт зэргийг тогтооход газар хөдлөлтийг заавал тооцох хэрэгтэй юм. Оршин суугчид орон сууцны худалдан авалт хийхэд тухайн орчны газар хөдлөлтөд тэсвэртэй байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

Хөрсний суулт, намаг

Энэ хүчин зүйл нь мөн л хотын хүрээлэн буй орчны нөхцөл байдал, оршин суугчид ая тухтай амьдрахад нөлөө үзүүлэх хүчин зүйл юм. Хөрсний суулт их, намаг бүхий газар барилга, зам, дэд бүтцийг барихдаа нарийвчилсан судалгаа, тооцоо хийсэн байх хэрэгтэй байна.

Уур амьсгал

Хот суурин газар амьдрах таатай орчин нөхцөлийг үнэлэхэд уур амьсгалын хүчин зүйл зайлшгүй ордог байна. Мөн хотжилт, барилгажилт, хүн амын өсөлт, бөөгнөрөл, аж үйлдвэржилт зэрэг нь эргээд хот орчмын агаар мандлын чанарт нөлөөлж, уур амьсгал өөрчлөгдөхөд нөлөөлж байна.

Үер

Үер бол оршин суугчдад асар их хохирол учруулдаг хүчин зүйл. Хот суурин газрыг төлөвлөхөд үерийн эрсдэлд нөлөөлөх байдлыг судлах, үерийн усны урсацыг тодорхойлох судалгааг хийсэн байх хэрэгтэй. Нөгөө талаар хотжилт нь өөрөө үерийн эрсдэлийг үүсгэх хүчин зүйл болж байна.

Агаарын бохирдол

Агаар мандалд ялгарч буй хий (хүхэр, азот, нүүрстөрөгчийн исэл, нүүрс устөрөгч ба озоны исэл) болон тоосонцор (утаа, тоос, шороо) нь олон төрлийн хаягдлаас үүсдэг. Агаарын бохирдол ихтэй хот нь иргэдийн амьдралын чанар, эрүүл мэндэд шууд нөлөөлнө.

Дуу чимээний бохирдол

Хотын оршин суугчдад нөлөөлж буй дуу чимээний нөлөөллийг судлах нь төвөгтэй асуудал юм. Гэвч дуу чимээ нь орчин үеийн хот суурин газрын хамгийн түгээмэл бохирдуулагчдын нэг юм. Дуу чимээний сөрөг нөлөө нь даралт ихсэх, бухимдал, стресс, сонсголын бэрхшээл; ажлын гүйцэтгэлд муугаар нөлөөлдөг бөгөөд, үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг бууралдаг байна.





Нийгэм, соёлын хүчин зүйлс:

Бөөгнөрөл, түгжрэл

Хамгийн их судлагдсан стрессийн хүчин зүйлүүдийн нэг бол бөөгнөрөл юм. Гэхдээ түүний нөлөөллийг бүрэн тодорхойлж чадаагүй байна. Бөөгнөрөл нь хүн хүссэн хэмжээнээсээ бага орон зайг мэдэрч байгааг хэлнэ. Хотын хүн амын хэт их өсөлт, нэг цэгт ихээр цуглах нь бөөгнөрөл үүсгэн, стресс үүсгэдэг байна.

Хөдөлгөөний ойлгомжтой байдал

Стресс үүсгэдэг нэг төрөл бол хот суурин газрын орчны чиг баримжаа, хөдөлгөөний хялбар байдалтай холбоотой асуудал юм. Хүмүүс хотоор зорчих үедээ барилга байгууламж, гудамж зам, ногоон байгууламж зэргийг цэгцтэй төлөвлөсөн хотыг илүүд үздэг байна.

Гэмт хэрэг, аюул заналхийлэл

Энэ нь хүнд айдас төрүүлдэг таагүй хүчин зүйл юм. Гэмт хэрэг, террорист халдлага, хүчирхийлэл зэрэг хүн амын дундах сөрөг хандлагууд энд багтана.

Дэд бүсүүд

Хүрээлэн буй орчин, нийгмийн зан үйлийн харилцан хамаарал нь хотын дэд бүсийг үүсгэдэг. Хот бүрт тодорхой хэсгээр зааглагдсан дэд бүсүүд аяндаа үүсдэг байна.

Эмэгтэйчүүд, залуус, ахмад настнуудад ээлтэй эсэх

Хүйсийн ялгаатай байдлаас үүсэх нийгмийн үүргийн хандлага нь хотын эмэгтэйчүүдэд хааяа асуудал дагуулдаг байна. Ахмад настнуудын хувьд эмийн сан, худалдааны төв, орон сууцны чанар, аюулгүй, тухтай байдал, тээврийн асуудал чухал юм. Залуусын хувьд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газрууд нэн шаардлагатай байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эсэх

Хотын ердийн нөхцөл байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүндрэл учруулдаг. Барилга байгууламжид нэвтрэх, нийтийн тээвэр ашиглахад тулгарч буй бэрхшээлүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд таагүй нөлөө үзүүлдэг.

Орон сууцны нөхцөл, хүрэлцээ

Тохиромжтой орон сууц, амьдрах таатай орчин гэсэн нийтлэг ойлголт байдаггүй. Энэ хүчин зүйлийн хувьд хүмүүс бүгд өөр өөрсдийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн таатай, таагүй байдлыг үнэлдэг байна. Тухайлбал зарим гэр бүл хотын төвд, зарим нь хотын захад, зарим нь цэцэрлэгт хүрээлэнд ойр амьдрахыг хүсдэг бол, нөгөө хэсэгт нь цэцэрлэгт хүрээлэн сонин биш байдаг байна. Иймд хот төлөвлөлтөнд олон төрлийн орон сууцны сонголтуудыг бий болгох нэг арга бол хот төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Архитектурын шийдэл, барилгын дизайн

Энд зөвхөн барилга байгууламжийн гадаад үзэмжээс гадна барилгын орчинд аюулгүй байдлыг мэдрэх хэрэгцээ, орц гарцын тодорхой байдал, нууцлал, нийгмийн харилцан үйлчлэл, хүн болон болон хүрээлэн буй орчны харилцааны асуудлууд багтдаг байна.

